

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/42/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаангом

2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317

Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799

Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батсайхан

Утас: 70453799

Цахим хаяг: batsaikhanS@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....
5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

ПРОКУРОРЫН ГАЗРЫН  
ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА  
Т.НЯМЖАВ ТАНАА

2023.02.24 № УВА-2023/42/НА-СТА-ТШЗ  
танай -ны № -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Увс аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Прокурорын газрын нягтлан бодогчоор ажиллаж байсан Ц.Анхзаяа нь албаны эрх мэдлээ ашиглаж нэмж олгосон цалин нэрээр 3.9 сая төгрөгийг хувийн данс руугаа шилжүүлсэн, хуурамч баримт бүрдүүлсэн, туслах ажилтнаар ажиллаж байсан П.Насанбатад давуу байдал үүсгэж 1.8 сая төгрөг илүү олгож төрд хохирол учруулсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.5 дахь заалтад “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.2 дахь заалтад “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр

9200000000

зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэх” Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад “Ашиг хонжоо” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг”, 3.1.3 дахь заалтад “Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах” гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг”, 3.1.4 дэх заалтад “Давуу байдал” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг”, 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтад “Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно”, 7.1.3 дахь заалтад “Албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах”, 7.1.6 дахь заалтад “Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх”, 7.1.7 дахь заалтад “Албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх” гэж заасантай нийцэхгүй, “Үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

### **Аудитын гол асуудал**

Прокурорын газрын нягтлан бодогч нь албаны эрх мэдлээ хэтрүүлж өөртөө болон бусдад давуу байдал бий болгож 5.7 сая төгрөгийг илүү олгосон, нуун дарагдуулах зорилгоор цалингийн тооцооны хүснэгт болон цалин олгох хүснэгтийг засварлаж хуурамч баримт үйлдсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink is written over a red square official stamp. The stamp contains Mongolian text and a central emblem. The signature is written in a cursive style.

М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>13,435,800.00</u></b>	<b><u>24,576,300.00</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	13,435,800.00	24,576,300.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	13,435,800.00	24,576,300.00
35420	Аж ахуйн материал	10,261,800.00	21,402,300.00
35470	Бусад хангамжийн материал	3,174,000.00	3,174,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>602,794,819.37</u></b>	<b><u>606,816,588.79</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	602,794,819.37	606,816,588.79
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	579,844,819.37	560,546,588.79
39201	Барилга, байгууламж, орон сууц	434,382,380.00	434,382,380.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-32,158,154.52	-42,877,539.44
39203	Авто-тээврийн хэрэгсэл	127,000,000.00	117,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-50,125,000.05	-63,375,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	113,583,062.71	124,961,616.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	-44,873,324.72	-55,917,051.84
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,071,727.47	62,571,727.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,035,871.52	-16,199,544.36
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	22,950,000.00	46,270,000.00
39301	Програм хангамж	550,000.00	1,320,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	22,950,000.00	44,950,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>616,230,619.37</u></b>	<b><u>631,392,888.79</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>40,000.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	40,000.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	40,000.00	00.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	40,000.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	40,000.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>616,190,619.37</u></b>	<b><u>631,392,888.79</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	616,190,619.37	631,392,888.79
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	190,038,414.75	212,038,414.75
51101	Өмч: - төрийн	190,038,414.75	212,038,414.75
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	195,972,084.34	189,174,353.76
51210	Өмнөх үеийн үр дүн	195,972,084.34	195,972,084.34
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-6,797,730.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	230,180,120.28	230,180,120.28
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>616,230,619.37</u></b>	<b><u>631,392,888.79</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>629,217,947.00</b>	<b>762,357,850.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>41,818,847.00</b>	<b>16,635,250.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	41,818,847.00	16,635,250.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>587,399,100.00</b>	<b>745,722,600.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	579,399,100.00	745,222,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	579,399,100.00	745,222,600.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,000,000.00</b>	<b>500,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00	500,000.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>619,643,441.51</b>	<b>769,155,580.58</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>619,643,441.51</b>	<b>767,072,247.31</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>589,162,221.41</b>	<b>687,950,644.51</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>364,567,909.72</b>	<b>436,160,631.62</b>
210101	Үндсэн цалин	243,753,664.38	272,321,209.34
210102	Нэмэгдэл	104,197,811.24	131,853,049.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,376,007.10	19,631,829.91
210104	Урамшуулал	00.00	12,354,542.73
210105	Гэрээт ажлын хөлс	3,240,427.00	00.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>45,714,340.38</b>	<b>52,179,292.79</b>
210201	Тэтгэврийн даатгал	31,507,179.16	35,995,957.42
210202	Тэтгэмжийн даатгал	3,610,291.35	4,142,578.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,884,933.01	3,314,062.98
210204	Ажилгүйдлийн даатгал	701,012.43	806,737.18
210205	Эрүүл мэндийн даатгал	7,010,924.43	7,919,956.57
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>22,339,477.80</b>	<b>23,150,291.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,205,693.80	2,238,991.00
210302	Түлш, халаалт	19,424,064.00	19,752,810.00
210303	Цэвэр, бохир ус	709,720.00	1,158,490.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>41,097,481.00</b>	<b>34,003,675.79</b>
210401	Бичиг хэрэг	11,697,600.00	12,097,650.00
210402	Тээвэр, шатахуун	9,143,702.00	12,324,682.79
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,873,879.00	3,946,963.00
210404	Ном, хэвлэл	2,404,300.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	878,000.00	673,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,100,000.00	4,961,380.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>18,483,500.00</b>	<b>52,925,500.00</b>
210604	Урсгал засвар	18,483,500.00	52,925,500.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,187,000.00</b>	<b>3,794,620.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,187,000.00	3,794,620.00

2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16,090,411.00	16,455,486.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,797,700.00	15,597,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,186,775.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	23,936.00	23,936.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	00.00
210807	Газрын төлбөр	214,500.00	214,500.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	78,682,101.51	69,281,147.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,422,000.00	3,300,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,158,000.00	1,440,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	53,102,101.51	64,541,147.31
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	30,481,220.10	79,121,602.80
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,040,000.00	2,220,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,040,000.00	2,220,000.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	00.00	2,083,333.27
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	2,083,333.27
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>9,574,505.49</b>	<b>-6,797,730.58</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>9,574,505.49</b>	<b>-6,797,730.58</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>587,399,100.00</b>	<b>745,722,600.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>587,399,100.00</b>	<b>745,722,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	579,399,100.00	745,222,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	579,399,100.00	745,222,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	8,000,000.00	500,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00	500,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>566,600,320.00</b>	<b>745,722,600.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>566,600,320.00</b>	<b>745,722,600.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>536,159,099.90</b>	<b>666,560,997.20</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	364,567,909.72	436,160,631.62
210101	Үндсэн цалин	243,753,664.38	272,321,209.34
210102	Нэмэгдэл	104,197,811.24	131,853,049.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,376,007.10	19,631,829.91
210104	Урамшуулал	00.00	12,354,542.73
210105	Гэрээт ажлын хөлс	3,240,427.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	45,714,340.38	52,179,292.79
210201	Тэтгэврийн даатгал	31,507,179.16	35,995,957.42
210202	Тэтгэмжийн даатгал	3,610,291.35	4,142,578.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,884,933.01	3,314,062.98
210204	Ажилгүйдлийн даатгал	701,012.43	806,737.18
210205	Эрүүл мэндийн даатгал	7,010,924.43	7,919,956.57
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22,339,477.80	23,150,291.00
210301	Гэрэл, цахилгаан	2,205,693.80	2,238,991.00
210302	Түлш, халаалт	19,424,064.00	19,752,810.00
210303	Цэвэр, бохир ус	709,720.00	1,158,490.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	40,855,961.00	42,444,175.79
210401	Бичиг хэрэг	11,701,100.00	12,097,650.00
210402	Тээвэр, шатахуун	8,898,682.00	12,324,682.79
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,873,879.00	3,946,963.00
210404	Ном, хэвлэл	2,404,300.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	878,000.00	673,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,100,000.00	13,401,880.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	00.00	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	18,446,000.00	82,425,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	10,000,000.00
210602	Тавилга	00.00	19,500,000.00

210604	Урсгал засвар	18,446,000.00	52,925,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,187,000.00</b>	<b>3,794,620.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,187,000.00	3,794,620.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,090,411.00</b>	<b>16,455,486.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,797,700.00	15,597,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,186,775.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	23,936.00	23,936.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	00.00
210807	Газрын төлбөр	214,500.00	214,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>25,958,000.00</b>	<b>8,451,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,800,000.00	4,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,158,000.00	3,951,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,260,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,260,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,260,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>20,798,780.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>20,798,780.00</b>	<b>00.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>20,798,780.00</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>20,798,780.00</b>	<b>00.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,798,780.00	00.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-20,798,780.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>01.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>01.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>01.00</b>	<b>00.00</b>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	190,038,414.75	230,180,120.28	186,397,578.85	606,616,113.88
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>190,038,414.75</b>	<b>230,180,120.28</b>	<b>186,397,578.85</b>	606,616,113.88
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	9,574,505.49	9,574,505.49
C08	<b>2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>190,038,414.75</b>	<b>230,180,120.28</b>	<b>195,972,084.34</b>	616,190,619.37
D01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>190,038,414.75</b>	<b>230,180,120.28</b>	<b>195,972,084.34</b>	616,190,619.37
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>190,038,414.75</b>	<b>230,180,120.28</b>	<b>195,972,084.34</b>	616,190,619.37
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-6,797,730.58	-6,797,730.58
D09	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>212,038,414.75</b>	<b>230,180,120.28</b>	<b>189,174,353.76</b>	631,392,888.79

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	745,222,600.0 0	668,320,997.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	745,222,600.0 0	668,320,997.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	742,962,600.0 0	666,060,997.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	493,959,600.0 0	436,160,631.62
210101	Үндсэн цалин	276,492,800.0 0	272,321,209.34
210102	Нэмэгдэл	187,207,800.0 0	131,853,049.64
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,910,000.00	19,631,829.91
210104	Урамшуулал	5,349,000.00	12,354,542.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,744,900.00	52,179,292.79
210201	Тэтгэврийн даатгал	44,310,900.00	35,995,957.42
210202	Тэтгэмжийн даатгал	4,358,500.00	4,142,578.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,486,800.00	3,314,062.98
210204	Ажилгүйдлийн даатгал	871,700.00	806,737.18
210205	Эрүүл мэндийн даатгал	8,717,000.00	7,919,956.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,243,600.00	23,150,291.00
210301	Гэрэл, цахилгаан	3,360,000.00	2,238,991.00
210302	Түлш, халаалт	23,690,100.00	19,752,810.00
210303	Цэвэр, бохир ус	3,193,500.00	1,158,490.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,450,300.00	42,444,175.79
210401	Бичиг хэрэг	11,477,900.00	12,097,650.00
210402	Тээвэр, шатахуун	12,810,600.00	12,324,682.79
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,698,800.00	3,946,963.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	951,000.00	673,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,512,000.00	13,401,880.00
2105	Нормативт зардал	1,500,000.00	1,500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.00	1,500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	82,426,700.00	82,425,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00
210602	Тавилга	19,500,000.00	19,500,000.00
210604	Урсгал засвар	52,926,700.00	52,925,500.00
2107	Томилолт, зочны зардал	3,800,000.00	3,794,620.00

210702	Дотоод албан томилолт	3,800,000.00	3,794,620.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,137,500.00</b>	<b>15,955,486.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,279,000.00	15,097,050.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	576,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	24,000.00	23,936.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	214,500.00	214,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10700000.00</b>	<b>8451000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,500,000.00	4,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,200,000.00	3,951,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2260000.00</b>	<b>2260000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,260,000.00</b>	<b>2,260,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,260,000.00	2,260,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	745,222,600.0	
		0	745,222,600.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	745,222,600.0	
		0	745,222,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	745,222,600.0	
		0	745,222,600.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>500,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>500,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>500,000.00</b>
	Бараа үйлчилгээний бусад зардал		500,000.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		500,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>500,000.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>500,000.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		500,000.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Монгол Улсын нутаг дэвсгэрт Эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж, хүний нөөцийг чадавхжуулах, дээд шатны прокурорын манлайлал, үүрэг хариуцлагыг сайжруулах, төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чанар, үр нөлөөг дээшлүүлэх үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Увс аймгийн Прокурорын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ний өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Прокурорын газар 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Увс аймгийн Прокурорын газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Увс аймгийн Прокурорын газар дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Прокурорын газар 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15.2 сая төгрөгөөр буюу 2.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	13,435.8	24,576.3	11,140.5
Үндсэн хөрөнгө	602,794.8	606,816.6	4,021.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>616,230.6</b>	<b>631,392.9</b>	<b>15,162.3</b>
Өр төлбөр	40.0	0.0	-40.0

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	190,038.4	212,038.4	22,000.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>616,230.6</b>	<b>631,392.9</b>	<b>15,162.3</b>

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд нийт 25.3 сая төгрөгийн аж ахуйн материал худалдан авч, 14.2 сая төгрөгийн материал зарцуулж, 11.1 сая төгрөгийн материалын үлдэгдэлтэй байгаагаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь 22.9 сая төгрөгийн өртөгтэй газрыг байгууллагын дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 741.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 3.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 745.2 сая төгрөгөөр баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 745.2 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 745.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 668.3 сая төгрөг буюу 89.7 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Улсын ерөнхий прокурор	745,222.6	668,320.9	76,901.6	89.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсвөөс 0.5 сая төгрөгийн санхүүжилтийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулж олгосныг сургалт сурталчилгаанд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Прокурорын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг Прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга Т.Нямжавд танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Прокурорын газар 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1/138 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг Прокурорын газрын хувьд суурь үзүүлэлтийг 2022 оны санхүүгийн тайлан гарах цаглаварт хугацаа болоогүй байгаа тул 2021 оны нийт зардлын дүнгээр сонгох нь зохимжтой гэж үзлээ.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлж, материаллаг байдлын түвшинг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 769.1 сая төгрөгөөс 1 хувиар буюу 7.7 сая төгрөгөөр дахин хянаж шинэчлэн тогтоов.

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага батлагдсан төсвийг арвилан хэмнэж, хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

##### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн

асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 119 мэдээллээс 111 мэдээллийг хугацаандаа, 8 мэдээллийг хугацаа хоцроож шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Прокурорын газрын нягтлан бодогчоор ажиллаж байсан Ц.Анхзаяа нь албаны эрх мэдлээ хэтрүүлж, өөртөө болон бусдад давуу байдал бий болгож 3.9 сая төгрөгийг хувийн данс руугаа шилжүүлсэн, туслах ажилтнаар ажиллаж байсан П.Насанбатад 1.8 сая төгрөг, нийт 5.7 сая төгрөгийг илүү олгосон байна. Уг гүйлгээг нуун дарагдуулах зорилгоор байгууллагын цалингийн тооцооны хүснэгт болон цалин олгох хүснэгтийг засварлаж хуурамч баримт бүрдүүлсэн нь гэмт хэргийн шинжтэй байгаа тул Төрийн аудитын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт заасны дагуу хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар шийдвэрлэв.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгдээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Өмнөх оны болон тайлант оны цалин бодолт болон цалингийн урьдчилгаа олголт, анхан шатны баримтын бүрдэл, иж бүрдлийг хянах нь зүйтэй гэж үзлээ.

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 5.7 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд төлбөрийн акт тогтоож, хууль хяналтын байгууллагад шилжүүлж шалгуулахаар шийдвэрлэв.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.1 Төлбөрийн акт

Прокурорын газрын нягтлан бодогчоор ажиллаж байсан Ц.Анхзаяа нь албаны эрх мэдлээ ашиглаж нэмж олгосон цалин нэрээр 3.9 сая төгрөгийг хувийн данс руугаа шилжүүлэн авсан, хуурамч баримт бүрдүүлсэн, туслах ажилтнаар ажиллаж байсан П.Насанбатад давуу байдал үүсгэж 1.8 сая төгрөг илүү олгож төрд хохирол учруулсанд төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хууль, тогтоомж зөрчсөн	1	5.7							1	5.7		
Дүн	1	5.7							1	5.7		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		/мянган төгрөгөөр/ Үүнээс		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн хөрөнгийн хувьдаа завшсан	1	5.7	1	5.7							1	5.7
Дүн	1	5.7	1	5.7							1	5.7

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР  /С.БАТСАЙХАН/

2023 оны 02 сарын 8-ны өдөр



УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 01/06/А.2060410  
УВА-2023/42/НА-СГА АМС

Улаангом

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Увс аймгийн Прокурорын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Прокурорын газрын нягтлан бодогчоор ажиллаж байсан Ц.Анхзаяа нь албаны эрх мэдлээ ашиглаж нэмж олгосон цалин нэрээр 3.9 сая төгрөгийг хувийн данс руугаа шилжүүлэн авсан, хуурамч баримт бүрдүүлсэн, туслах ажилтнаар ажиллаж байсан П.Насанбатад давуу байдал үүсгэж 1.8 сая төгрөг илүү олгож төрд хохирол учруулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтад "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 5.1.5 дахь заалтад "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.", 16.5.2 дахь заалтад "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5 дахь заалтад "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт "Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 39.1.2 дахь заалтад "Албаны эрх мэдлээ хэтрүүлэх" Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад "Ашиг хонжоо" гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгосны төлөө өөрт нь болон бусдад буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг", 3.1.3 дахь заалтад "Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах" гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг", 3.1.4 дэх заалтад "Давуу байдал" гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг", 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтад "Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно", 7.1.3 дахь заалтад "Албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах", 7.1.6 дахь заалтад "Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх", 7.1.7

дахь заалтад “Албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3-д “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”, 4.2.3.7-д “Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан” гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрд учирсан хохирол 5,700.0 мянган /таван сая долоон зуу мянга/ төгрөгийг гэм буруутай албан тушаалтнуудаар төлүүлж, Орон нутгийн орлогын 100150000962 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Увс аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Д.Галбадрах, Тамгын хэлтсийн дарга Т.Нямжав, нягтлан бодогч Ц.Сугар нарт хариуцуулав.
3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АХЛАХ АУДИТОР

С.БАТСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

У.БАТСУУРЬ

